*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралт*

# АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН А.ОТГОНБАЯРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа | Хүрсэн түвшин | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| Зорилт 1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны хөтөлбөрийн "Хүний хөгжил" бүлгийн "Тэгш хүртээмжтэй боловсрол" дэд бүлгийн хүрээнд: | | | | | | | | | |
| 1 | 1.1 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн ачааллыг тэнцвэржүүлэх | Анги дүүргэлтийн норм хангасан бүлгийн эзлэх жин | Цэцэрлэг 22.2% ЕБС 45.5% | - | Цэцэрлэг 26.2% ЕБС 46.5% | 01 | 12 | 2024-2025 оны хичээлийн жилд төрийн өмчийн 19, хувийн хэвшлийн 5 ерөнхий боловсролын сургуулийн 813 бүлэгт 26940 сурагч суралцаж, анги бүлгийн дүүргэлт 33.1, / бага анги – 34.9, дунд анги – 32.8, ахлах анги - 29.6 /, 1-р ангийн бүлэг дүүргэлт 34.5 байна. 2024-2025 оны хичээлийн жилд төрийн өмчийн 32, төрийн бус өмчийн 6 нийт 38 цэцэрлэгийн 310 бүлэгт 8907 хүүхэд сургалтад хамрагдаж, бүлэг дүүргэлт 28.7 байна. Энэ хичээлийн жилд 8-р сургуулийн өргөтгөл 320 хүүхдийн суудалтай хичээлийн байрыг ашиглалтад оруулснаар тус сургуулийн ачаалал буурсан. 2025-2026 оны хичээлийн жилд 600 суралцагчтай ахлах сургуулийг шинээр байгуулахаар төлөвлөж байна. Ингэснээр сургуулиуд дээр байгаа ахлах ангийн хүүхдийн ачаалал 10.2%-иар буурахаар байна.3-р сургуулийн 960 хүүхдийн суудалтай барилга шинээр ашиглалтад орсноор тус сургууль нийтдээ 1280 хүүхдийн суудалтай болж, тухайн сургуулийн анги дүүргэлт буурна. Мөн баригдаж | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байгаа цэцэрлэгийн 2 барилга, сургуулийн 4 барилгыг ашиглалтад хүлээж авснаар орон нутгийн сургууль, цэцэрлэгийн бүлэг дүүргэлтийг бууруулна гэж тооцоолсон. Шинээр ашиглалтад орсон сургуулийн барилгуудыг хүлээж авсантай холбогдуулан Боловсролын газрын даргын 2025 оны А/120 тоот тушаалаар хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойргийг шинэчилэн тогтоосон. | |
| 2 | 1.2 Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг эхлүүлэх | Ашиглалтад орсон эсэх | 2 барилга ашиглалтад орсон | 1 | - | 01 | 04 | 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр улсын төсвийн 7.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар баригдсан 8-р сургуулийн 320 хүүхдийн өргөтгөлийн барилгыг ашиглалтад хүлээн авч тус сургуулийн ахлах ангийн 350 гаруй сурагч 1 ээлжээр хичээллэх боломж бүрдсэн. | 100 |
| 3 | 1.3 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилгад шаардлагатай засвар, үйчилгээг хийж сургалтын таатай орчин бүрдүүлэх | Засвар хийгдсэн сургууль, цэцэрлэгийн тоо | 15 байгууллага | - | 5 цэцэрлэг<br>6 сургууль | 01 | 09 | 2025 онд боловсролын салбарын 13 байгууллагад орон нутгийн төсвийн 3,141.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар засвар үйлчилгээ хийгдэхээр төлөвлөж ажлууд хуваарийн дагуу явагдаж байна. Үүнд:<br>1. 15 дугаар сургуулийн гал тогооны өргөтгөлийн барилга барих-282.0 сая<br>2. Согоот баг.Баян-Өндөр сумын 14-р сургуулийн дутуу баригдсан өргөтгөлийг буулгах-300.0 сая<br>3. 24-р цэцэрлэгт хэсэгчилсэн засвар хийх-196.0 сая<br>4. Оюу цэцэрлэгийн гадна цахилгааны ажил шинээр хийх-26.5 сая<br>5. 7-р сургуулийн спорт заалны шалыг засварлах-120.0 сая<br>6. 5 дугаар сургуулийн их засвар, сургалтын байрны зүүн жигүүрийн халаалтын систем засварлах-284.0 сая | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 7. 9 дүгээр цэцэрлэгт засвар хийх-250.0 сая<br>8. 1 дүгээр сургуулийн хичээлийн 1-р байрны цахилгаан, сантехникийн их засвар хийх-300.0 сая<br>9. 1 дүгээр цэцэрлэгийн гадна талд дулаалгатай фасад хийх-450.0 сая<br>10. Баянцагаан баг.18 дугаар сургуулийн дээвэр засварлах-131.9 сая<br>11. 20 дугаар сургуулийн гадна, дотно камержуулалт хийх-155.3 сая<br>12. Дэгдээхэй цэцэрлэгийн гадна талбайн тохижилт хийх-350.0 сая<br>13. Зэст баг. 21 дүгээр цэцэрлэгийн гадна ИШС шинэчлэх ажил-295.4 сая | |
| 4 | 1.4 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийг шаардалгатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшил, хэрэглэгдэхүүнээр хангах | Шаардалгатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшил, хэрэглэгдэхүүнээр хангагдсан сургууль, цэцэрлэгийн тоо | 17 сургууль 31 цэцэрлэг | 17 байгууллага | - | 01 | 06 | 2025 онд орон нутгийн төсвийн 602.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийг шаардалгатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшил, хэрэглэгдэхүүнээр хангахаар төлөвлөж ажлууд төлөвлөгөөний дагуу явагдаж байна. Үүнд:<br>1. Ерөнхий боловсролын сургуулиудад шинээр байгуулах хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих танхимд тоног төхөөрөмж худалдан авах-100.0 сая<br>2. Ерөнхий боловсролын сургуулиудад хүүхдийн хөгжлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах -232.9 сая<br>3. Ерөнхий боловсролын 6-11-р ангиудад 1000 ном төсөл уншлагын хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай худалдан авалт хийх-250.0 сая<br>4. 13 дугаар сургуулийн Монгол хэлний кабинетэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах-20.0 сая | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | 1.5 Хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн олон талт төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, сурагчдын дугуйлан, секцэд хамрагдалтыг нэмэгдүүлэх | Төсөл арга хэмжээний тоо Дугуйлан секцэд хамрагдалтын хувь | Төсөл арга хэмжээний тоо- 1 Дугуйлан секцэд хамрагдалт-30.6% | - | Төсөл арга хэмжээний тоо- 1 Дугуйлан секцэд хамрагдалт-32.6% | 01 | 12 | 2024-2025 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулиуд тус бүр 15-18 нэр төрлийн сонгон, секц, дугуйланг хичээллүүлж, хүүхдийн авьяас чадварыг дэмжиж ажилласан байна. Аймгийн хэмжээнд 9430 хүүхэд буюу нийт хүүхдүүдийн 35% нь төрөл бүрийн сонгон, секц, дугуйланд хамрагдсан байна. | 70 |
| 6 | 1.6 Сурагчдад эх оронч үзэл төлөвшүүлж, амьдрах ухаанд суралцуулах арга хэмжээг байгууллага, иргэдтэй хамтран зохион байгуулах | Зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан сурагчдын тоо | - | - | 1 арга хэмжээ<br>1500 сурагч | 01 | 12 | 2025-2026 оны хичээлийн жилд аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Зэвсэгт хүчний 186 дугаар ангитай хамтран “Эх оронч аялал-орон нутаг судлал” интеграци хичээлийг төрийн болон хувийн хэвшлийн 23 сургуулийн 11 дүгээр ангийн 1117 сурагчийг хамруулахаар төлөвлөж байна. | Хэрэгжих хугацаа болоогүй |
| 7 | 1.7 Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлж өмчийн бүх хэлбэрийн ЕБС, цэцэрлэгийн сургалтын чанарыг дээшлүүлнэ. | ЕБС-9-р ангийн сурагчдын унших чадвар, математикийн хичээлийн гүйцэтгэлийн дундаж хувь, СӨББ-Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний гүйцэтгэлийн хувь | ЕБС-Унших чадвар 41.1% Математик 33.7%<br>СӨББ-70.2% | - | ЕБС-Унших чадвар 52.0% Математик 35.0%<br>СӨББ- 71.0% | 01 | 12 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 176 дугаар тогтоол, Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11 –ний өдрийн “Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх ажилд дэмжлэг үзүүлэх, хэрэгжүүлэх, бэлтгэл хангах тухай” А/60 тушаалыг үндэслэн бага боловсролын шинэчлэлийн сургалтыг бага боловсролын сургалтын менежер-18, I ангийн 71 багш, V ангийн 66 багш нийт 155 хүн зохион байгуулсан. СӨББ-ын сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх дэмжлэгийн багийн сургагч багш нарын сургалтыг 2025 оны 08 дугаар сарын эхний 7 хоногт, үндэсний түвшний сургалт 2, 3 дахь 7 хоногт 347 багш, 62 удирдах ажилтанд зохион байгуулагдана. ЕБС-ийн 9-р ангийн сурагчдын унших чадвар, математикийн хичээлийн гүйцэтгэл, СӨББ-ын сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ БҮТ-өөс хийгдээгүй байна. | 70 |
| 8 | 1.8 Үндэсний бичгийн хэрэглээг төрийн албан хаагчид, иргэд, хүүхэд залуучуудын дунд түгээн | Сургалт, нөлөөллийн үйл ажиллагааны тоо, | 3 арга хэмжээ 380 хүн | - | 3 арга хэмжээ 400 хүн | 01 | 12 | Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлийг аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 21-ний А/158 дугаар захирамжаар шинэчлэн | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дэлгэрүүлж, иргэдийн эх хэлний боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах. | нийт хамрагдсан хүний тоо | | | | | | байгуулж, 2025 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 11 арга хэмжээтэйгээр боловсруулж, хэрэгжилтийг хангаж байна. Үндэсний бичгийн хэрэглээг төрийн албан хаагчид, иргэд, хүүхэд залуучуудын дунд түгээн дэлгэрүүлж, иргэдийн эх хэлний боловсролыг дээшлүүлэх арга хэмжээнд 2025 оны орон нутгийн төсөвт 10.0 сая төгрөг тусгагдсан. | |
| 9 | 1.9 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд “Өдөр бүр нэг аяга сүү “ арга хэмжээг хэрэгжүүлэх. | 6-9-р ангийн хүүхдийн хамрагдалтын хувь | - | - | 100% | 01 | 12 | Аймгийн хэмжээнд төрийн өмчийн 17 сургуулийн 6-9-р ангийн 8353 сурагчийг “Өдөр бүр нэг аяга сүү” арга хэмжээнд хамруулахаар төлөвлөж аймгийн Засаг даргын 2025 оны А/386 дугаар захирамжаар зардлыг шийдвэрлэсэн. 2025 оны 1-4-р сард арга хэмжээнд...сурагч хамрагдаж, гүйцэтгэлээр 419.1 сая төгрөгийн санхүүжилтийг төрийн өмчийн сургуулиудад олгосон байна. | 100 |
| 10 | 1.10 Сургалтын чанар, ажлын үр дүнгээр шалгарсан болон улс, олон улсын олимпиад, уралдаан тэмцээн, ЭЕШ-д амжилт гаргасан багш, сурагчдыг урамшуулах, дэмжлэг үзүүлэх | Тухайн жилд амжилт гаргасан багш, сурагчдын урамшуулалд хамрагдалтын хувь | Багш-4, сурагч-25 | - | 100% | 04 | 12 | 2024 онд улс, олон улсын олимпиадад амжилт гаргасан багш, сурагчдыг урамшуулах зардал 11.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэсэн. 2025 онд улс, олон улсын олимпиадад амжилт гаргасан багш, сурагчдын урамшууллыг төсвийн тодотголд тусгуулахаар төлөвлөж байна. 2025 оны ЭЕШ 2025 оны 06 дугаар сарын 18-наас 21-ний өдрүүдэд зохион байгуулагдана. | 70 |
| 11 | 1.11 Багшийг хөгжүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах | Төлөвлөсөн ажлын биелэлтийн хувь | 90% | - | 100% | 03 | 12 | Аймгийн ИТХ-ын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 02/16 дугаар тогтоолоор “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг батлуулж уг хөтөлбөрийн хүрээнд боловсролын салбарын хүний нөөцийн бодлогыг боловсруулах, ЭЕШ, анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлэх, ахлах сургуулийн багш нарыг бэлтгэх зэрэг олон талт арга хэмжээг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж байна. | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | 1.12 Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийг гадаадын, их дээд сургууль, коллежид суралцахад дэмжлэг үзүүлэх | Дэмжлэгт хамрагдсан төгсөгчийн тоо | - | - | 20 төгсөгч | 03 | 09 | БНСУ-ын Сүнчон их сургуулийн хэлний бэлтгэлд тэтгэлэгээр суралцах төгсөгчдийн бүртгэлийг Боловсролын газарт хийж 24 сурагч бүртгүүлсэн байна.Бүртгэлд хамрагдсан ЕБС төгсөгчид болон тэдний эцэг эх, асран хамгаалагчдад шаардлагатай мэдээлэл зөвлөгөөг 3 удаа өгсөн. 2025 оны ЭЕШ 2025 оны 06 дугаар сарын 18-наас 21-ний өдрүүдэд зохион байгуулагдах бөгөөд дээрх сурагчид элсэлтийн шалгалтад оролцсоны дараа БНСУ-ын ЭСЯ-нд виз мэдүүлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. | 70 |
| Зорилт 2. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны хөтөлбөрийн “Эдийн засгийн бодлого” бүлгийн “Аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл” дэд бүлгийн хүрээнд: | | | | | | | | | |
| 13 | 2.1 Аймгийн нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлыг олон нийтийн оролцоотой зохион байгуулах. | Аймгийн нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудын хадгалалт хамгаалалтын хувь | 100% | 100% | - | 01 | 06 | Аймгийн нутаг дэвсгэрт орших 28 газрын 343 түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг хулгайн гэмт хэрэг зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтийн хяналт, оролцоог сайжруулах зорилгоор сумдын Засаг дарга нар, 20 малчин өрхтэй түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээгээр хамгаалж буй өрхүүдийн урамшуулал болон дурсгалт газруудад мэргэжлийн байгууллагаас хяналт тавих зардалд 10.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан. | 100 |
| 14 | 2.2 Соёл, урлагийн байгууллагуудыг шаардлагатай тоног, төхөөрөмж техник хэрэгсэл, эд хогшлоор хангах. | Шаардлагатай тоног, төхөөрөмж техник хэрэгслээр хангагдсан байгууллагын тоо | 4 байгууллага | 1 байгууллага | - | 01 | 06 | Тайлант хугацаанд аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газарт шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авахад орон нутгийн төсвөөс 65.9 сая төгрөг зарцуулсан байна. | 100 |
| 15 | 2.3 Нийгмийн амьдралд “Хотын соёл-Хамтын соёл”-ын хэм хэмжээг төлөвшүүлэх, бүх нийтийн соёлын боловсролыг | Зохион байгуулсан арга хэмжээний тоо Хамрагдсан хүний тоо | 20000 | - | 21000 | 01 | 12 | Тайлант хугацаанд "Урин хавар-2025" яруу найргийн наадам, “Үндэсний бичиг үсэг, номын баяр-2025”, соёлын төвүүдээс хэрэгжүүлсэн кино боловсрол олгох арга хэмжээ, музейн боловсрол олгох хөтөлбөр, “Эх | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дээшлүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах. | | | | | | | хэлний өдөр", "Үндэсний хувцасны өдөр" зэрэг бүх нийтийн соёлын боловсролын дээшлүүлэхэд чиглэсэн 68 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж 14000 гаруй иргэд, хүүхэд, залуучууд хамрагдсан байна. | |
| 16 | 2.4 Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр олон талт арга хэмжээ зохион байгуулах | Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн тухайн жилд хийсэн борлуулалтын орлогын мөнгөн дүн | 37.7 сая | - | Олон талт арга хэмжээг зохион байгуулж соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн борлуулалтын орлого нэмэгдсэн байна. | 01 | 07 | "Эрдэнэтэд үйлдвэрлэв- 2025" соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэнг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Баян-Өндөр сумын ЗДТГ, Оёдолчдын холбоо, Гар урчуудын холбоо, Зураач урчуудын холбоо зэрэг ТББ-удтай хамтран 2025 оны 06 дугаар сарын 27, 28-ний өдрүүдэд А.Амарын талбайд зохион байгуулахаар төлөвлөж байна. | 70 |
| 17 | 2.5 Орон нутгийн иргэдэд улсын хэмжээний уран бүтээлийг хүртээл болгох. | Уран бүтээлийн тоо | 1 уран бүтээл | - | 1 уран бүтээл | 01 | 12 | Хэрэгжих хугацаа болоогүй. | Хэрэгжих хугацаа болоогүй |
| 18 | 2.6 Олон улс, улс, бүсийн хэмжээнд зохион байгуулагдах соёлын уралдаан, тэмцээнд оролцох уран бүтээлчид, иргэд, хүүхэд залуучуудад дэмжлэг үзүүлэх. | Тухайн жилд дэмжлэг үзүүлсэн иргэдийн тоо | 1 хамтлаг, 2 уран бүтээлч, 1 иргэн | - | 5 иргэн, уран бүтээлч | 01 | 12 | Тайлант хугацаанд АНУ-д төгөлдөр хуурын уралдаанд Орхон аймгаас оролцох сурагч Л.Сарангуад1.2 сая, АНУ-ын Бостон хотод 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулагдах төгөлдөр хуурын олон улсын "А" зэрэглэлийн "Кришиндо" тэмцээнд Орхон аймгаас оролцох 7 хүүхэд, 1 багшийн замын зардалд 4.0 сая, нийт 5.2 сая төгрөгийн дэмжлэгийг 9 иргэн үзүүлсэн байна. | 100 |
| 19 | 2.7 Төрийн болон хувийн хэвшлийн соёл, урлагийн байгууллага, иргэдээс гаргасан санал, санаачлага, шинэ уран бүтээлд дэмжлэг үзүүлж хамтарч ажиллах. | Дэмжлэг үзүүлсэн байгууллагын тоо Иргэд, уран бүтээлчдийн тоо | 4 байгууллага 12 иргэн, уран бүтээлч | - | 2 байгууллага 5 иргэн, уран бүтээлч | 01 | 12 | Тайлант хугацаанд "Үндэсний бичиг үсэг, номын баяр-2025" арга хэмжээнд 4.0 сая, "Уран бийр" сургалтын төвийн багш Д.Цэгмидийн ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн сурагчдын дунд явагдах гар зургийн уралдаан болон Улаанбаатар хотод зохион байгуулах уран зургийн үзэсгэлэнгийн зардалд 3.1 сая, "Дэнжийн цуурай" төрийн бус байгууллагаас Улаанбаатар хот болон Хөвсгөл аймгийн уран бүтээлчидтэй хамтран зохион байгуулсан "Тэнгэрийн аялгуу" | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үндэсний хөгжмийн тоглолтын зардалд 500.0 мянга, Дуу бүжгийн "Эрдэнэт" чуулгын уран бүтээлч С.Ариун-Эрдэнэ, Х.Мөнхбаяр, Н.Нямсүрэн нарын "Дэлхий аргадах ижий" уран бүтээлийн тоглолтын зардалд 3.0 сая, Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл дор төрийн ордонд зохион байгуулагдсан "Монгол дархны уламжлал, шинэчлэл" сэдэвт үндэсний анхдугаар чуулганд Орхон аймгаас оролцох иргэдийн замын зардалд 622.0 мянга, Баян-Өндөр сумын Даваат багийн "Аялгуу" соёлын төвөөс аймгийн соёл, урлагийн байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд явуулсан "Соёлынхон" нөхөрсөг тэмцээнийг зохион байгуулах зардалд 2.9 сая, дэлхийн яруу найргийн өдрийн хүрээнд иргэдийн дунд явагдсан "Урин хавар-2025" нээлттэй уралдаанд шаардагдах зардалд 2.1 сая, Жаргалант соёл, мэдээллийн төвийн Орон нутаг судлах танхимын ажилтан Б.Нэмэхнямын 2025 оны "Эрдэнэт хотын болон Анхдагч, илгээлтийн эздийн өдөр"-өөр зохион байгуулагдах "Эрдэнэсийн өнгө" үзэсгэлэнд 17.8 сая, Аймгийн насан туршийн суралцахуйн төвөөс “Наурызын баяр”-ын хүрээнд Казах үндэстний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулсан гар зураг, ханын сонины уралдааны шагналын зардалд 1.5 сая, нийт 31.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. | |
| Зорилт 3. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны хөтөлбөрийн “Эдийн засгийн бодлого” бүлгийн “Шинжлэх ухаан, инновацид суурилсан Ухаалаг хот” дэд бүлгийн хүрээнд: | | | | | | | | | |
| 20 | 3.1 Инновацыг олон нийтэд сурталчлан зөвлөх үйлчилгээг үзүүлж, гарааны компанийг хөгжүүлэх. | Бүртгэгдсэн гарааны компаний тоо | 9 | - | 3 | 01 | 12 | Хэрэгжих хугацаа болоогүй. | Хэрэгжих хугацаа болоогүй. |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 4."Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтын хүрээнд | | | | | | | | | |
| 21 | 4.1 ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Тайлан мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн эсэх | Тайлан мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн | Биелэлтийг эхний хагас жилийн байдлаар гаргаж тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна. | Биелэлтийг жилийн эцсийн байдлаар гаргаж тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна. | 01 | 12 | ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж 2025 оны 1-р улиралд батлуулсан. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж ажилласан. | 100 |
| 22 | 4.2 Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | Ёс зүйн болон бусад зөрчил гаргаагүй байх | Ёс зүйн болон бусад зөрчил гаргаагүй | Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байх | Хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байх | 01 | 12 | Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийн дагуу холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 |
| 23 | 4.3 Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх | Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо | 63 өргөдөл, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэсэн. | Өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэж хариуг өгсөн байх | Өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэж хариуг өгсөн байх | 01 | 12 | Иргэдээс ирүүлсэн 23 өргөдөлийг шийдвэрлэж хариуг хугацаанд нь өгсөн. | 100 |
| 24 | 4.4 Засаг дарга, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэг, комисст ажиллах, өгөгдсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх | Комисс, ажлын хэсэгт ажилласан тоо | 5 | Шийдвэрийн дагуу ажиллах | Шийдвэрийн дагуу ажиллах | 01 | 12 | Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын шуурхай хурлаас ирүүлсэн 21 удаагийн үүрэг даалгаварыг биелүүлж, хариуг хүргүүлсэн. Мөн аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан 1 ажлын хэсэгт орж ажилласан. | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа | Хүрсэн түвшин | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1. | 2.1 Мэргэшүүлэх сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан байна. | Сургалтад хамрагдсан. | Сургалтад хамрагдсан байна. | - | 01 | 04 | Удирдлагын академийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн. | 100 |
| 2. | 2.2 Албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг чадвараа дээшлүүлэх холбогдох хууль тогтоомжийг судлах, сургалтад хамрагдах | Сургалтуудад хамрагдсан байна. | Сургалтуудад хамрагдсан. | - | Шинээр гарсан хууль тогтоомжийг судалж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, сургалтад хамрагдсан байна. | 01 | 12 | ТАЗ, Боловсролын яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас зохион байгуулсан цахим сургалтуудад бүрэн хамрагдсан. | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн А.Отгонбаяр /.................../ 2025.06.09

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*